

**СОЁЛЫН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

2021.04.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/33/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Соёлын сайд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Б.Сэржмядаг Аудитор Ч.Дашдаваа

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Төсвийн шууд захирагч	27	18	9			17	1		
2	Засгийн газрын тусгай сан	2		2						
3	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1	1				1			
4	Төсвийн ерөнхийлөн захирагч	1	1					1		
	ДҮН	31	20	11			18	2		

Гурав. Аудитын үр дүн

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТЕЗ	14	14,395.0	1	0.5	5	14,264.6	8	129.9
2	ЗГТС	1	10,000.0			1	10,000.0	-	-
3	ТШЗ	75	585.1	6	11.4	33	432.6	36	141.1
4	ТӨААН	3	106.4			2	81.8	1	24.6
	Дүн	93	25,086.5	7	11.9	41	24,779.0	45	295.6

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулбал:

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Завхан Баянтэс сумын соёлын төвийн барилгын хөрөнгө оруулалтын ажлын хэмнэлт 0.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын ажлын хэмнэлтээс үүссэн 0.5 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын улсын төсөвт төвлөрүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Кино урлагийг дэмжих сан байгуулагдаж, 2020 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тус санд 10,000.0 сая төгрөгийн төсөв баталсан. Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам батлагдаагүйгээс сангийн хөрөнгийг зарцуулаагүй, үлдэгдлийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална” гэж заасан боловч тус журам гараагүй байна. Мөн Кино урлагийг дэмжих тухай хууль батлагдаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журмыг холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх, эрх зүйн орчныг бий болгож, холбогдох арга хэмжээ авч зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 3

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2016-2019 онуудад ашиглалтад орсон 9 төсөл арга, хэмжээний 6,108.1 сая төгрөг, улсын төсвийн санхүүжилт нь зогссон 1,319.1 сая төгрөг, нийт 7,417.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 2020 онд ашиглалтад орсон 32 төсөл, арга хэмжээний 54,285.0 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэн”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.8-д “хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барилга байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлэн өгөх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 4

Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 4,016.1 сая төгрөгийн 8 хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт барьцаа хөрөнгийн дансанд байршиж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухай үлдэгдлийг тухай шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-д “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 5

Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Чингис хааны музейн үзмэрүүдийг сэргээн, засварлах, сан хөмрөгийг нэмэгдүүлэх 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг холбогдох журмын дагуу сонгон шалгараагүй, гүйцэтгэгч компани, хувь хүн тодорхойгүй, үнэлгээний хорооны шийдвэрээр зарим ажлуудыг нээлттэй тендер зарлахыг зөвлөсөн байхад Төрийн нарийн бичгийн даргын А/72 дугаар тушаалаар шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, 46.1.3-т “үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 6

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн төсвөөс үндсэн хөрөнгө худалдан авахад 631,1 сая төгрөг, урсгал засварт 200.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа босго үнэд багтаах, нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж Төрийн нарийн бичгийн даргын 44 тушаалаар 9.9-80.0 сая төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, сангийн сайдын 2014 оны Тушаалд өөрчлөлт оруулах тухай 55 дугаар тушаалаар баталсан “төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйл, Худалдан авах ажиллагааны журмыг сонгох 8.1-д “Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно”, 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 8.5-д Энэ хуулийн “8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 21 дүгээр зүйл Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэх 21.1-т “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Алдаа, зөрчилтэй асуудал 7

Төрийн нарийн бичгийн даргын “Нэмэгдэл хөлс олгох тухай” А/64 тоот тушаалаар зарим албан хаагчдад илүү цагийн хөлс олгохдоо ТНБД өөртөө болон дээд албан тушаалтанд илүү цагийн хөлс олгохоор тушаал гаргасан нь Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Төрийн нарийн бичгийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.6.3-т “яамны төсвийн ерөнхий менежерийн хувьд сайдтай үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнүүлэх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад цалин хөлсийг олгохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх зөвлөмж өгөх.

Алдаа, зөрчилтэй асуудал 8

Байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй, тайлант оны хөтөлбөр арга, хэмжээнд батлагдаагүй ТББ-ын хандивын тоглолтын үйл ажиллагаанд 92.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 25 дугаар зүйлийн 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж удирдах зөвлөмж өгөх.

Алдаа, зөрчилтэй асуудал 9

Барилгын чанарын баталгааны барьцаа хөрөнгийн дансанд 28 төсөл арга хэмжээний 2,349.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2014-2018 онд үүссэн 4.6 сая төгрөгийн чанарын хяналтын баталгааны барьцаа байршиж байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Барьцаа дансанд байршиж буй 2014-2018 онуудын засварын ажлын гүйцэтгэлийн чанарын хяналтын баталгааны барьцаа 4.6 сая төгрөгийг зохих журмын дагуу гүйцэтгэгчид олгох зөвлөмж өгөх.



СОЁЛЫН САЙД Ч.НОМИН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1337
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 25,086.5 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг” “Тохиолдсон байх”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

\\10.10.10.20\Bichig_Khared\Yawsan_Bichig\2021\0426auditin 2-R_Gazar41.Docx


001030478

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ